

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 110,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



Зүүн болон Өмнөд Африкийн төлөө залбирал

Ботсвана нь Өмнөд Африкт орших далайд гарцгүй улс бөгөөд нийслэл нь Габороне юм. Энэ улс нь Африкийн цөөн тооны ардчилсан орнуудын нэг юм. Христ итгэл хүн амын 70 хувийг эзэлдэг. Үүний зэрэгцээ, эмэгтэйчүүд олон сорилттой тулгардаг бөгөөд боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, эдийн засгийн боломжид хязгаарлагдмал хандалттай байдаг. Нийгмийн хэвшмэл ойлголт нь эмэгтэйчүүдэд асран хамгаалагчийн үүргийг хэт ачаалалтай үүрүүлж, хувийн хөгжлийг нь хязгаарладаг. Ботсвана дахь эмэгтэйчүүдийн гуравны хоёр нь хүчирхийлэлд өртсөн байдаг нь дэлхийн дундаж үзүүлэлтээс хоёр дахин их юм. TWR Women of Hope нь эдгээр сорилтод хариу өгөн, сүнслэг өсөлт, сэтгэлийн эдгэрэлтийг дэмжин, эмэгтэйчүүдэд итгэл найдвар хайрладаг.



카카오톡 채널에서 '소망의 여인들' 채널을 추가하시면 매주 월요일에 한국어 기도카드를 받으실 수 있습니다.

1. Бурхан минь, Ботсван улсын Селеби-Фикве хотод, ялангуяа Христэд итгэдэггүй нөхөртэй итгэгч эмэгтэйчүүдийн дунд байгаа гэр бүлийн хүчэрхийлэлийн түвшин өндөр байна. Та энэ хүчирхийлэлийг зогсоогооч хэмээн залбирч байна. (Ром 8:18)

2. Эзэн минь, Бурунди улсад соёлын болон хууль эрх зүйн шинэчлэл хийгдэж, эмэгтэйчүүдэд эд хөрөнгө өмчлөх болон өв залгамжлах эрх тэгш олгогдох болтугай. (Сур. 31:16)

3. Эцэг минь, Коморын арлуудын эмэгтэйчүүд эрчүүдтэй адил чанартай боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ авах нөхцөл нь тэгш хүртээмжтэй байх болтугай. (Гал. 3:28)

4. Бурхан минь, Жибүтигийн эмэгтэйчүүд ядуурлын асуудлыг шийдэж чадахуйц ажил эрхлэх боломжуудтай болох болтугай. (Фил. 4:19)

5. Эзэн минь, Эритрейд байгаа эмэгтэйчүүд сайн боловсрол болон эх барих тусламж үйлчилгээ авах нөхцөл хангагдах болтугай. (Иер. 33:6)

6. Эсватинийн бэлэвсэн эмэгтэйчүүдийг хүндэтгэж, ялгаварлан гадуурхахаас хамгаалаач. Аав аа, тэдний хэрэгцээг хангаж, шударга ёсыг тогтоох болтугай. (Дуу 68:5)

7. Эзэн минь, Өмнөд Африкийн охид эмэгтэйчүүд өөрсдийн үнэлэмжийг танаас олж авч, өөрсдийгөө аймшигтай бөгөөд гайхамшигтай бүтээгдсэн гэдгээ ухаарах болтугай. (Дуу 139:14)

8. Бурхан минь, Занзибар болон Пембагийн эмэгтэйчүүдэд зориулсан сэтгэл заслын сургалтыг үргэлжлүүлж буй Найдвар доторх эмэгтэйчүүдмйн баг болон хамтрагчдыг бэхжүүлээч. 2025 оны 10-р сард зохион байгуулагдах удирдагчдын сургалтыг Та удирдан чиглүүлээч. (Лука 4:18)

9. Эзэн минь, Кени улсын эмэгтэйчүүд амьдралын бүхий л салбарт шийдвэр гаргах, удирдах түвшинд оролцдог болох болтугай. (Сур. 31:26)

10. Бурхан минь, Мадагаскар дахь гэр бүлийн хүчирхийлэл эцэслэгдэж, эмэгтэйчүүдэд шударга ёс тогтож, шаардлагатай дэмжлэг туслалцааг авах болтугай. (Дуу 46:5)

11. Эзэн минь, Малавигийн хөдөөгийн эмэгтэйчүүд эх барих тусламж авахад тулгарч буй соёлын саад бэрхшээлүүдийг арилгахад Та туслаач. Тэдний засгийн газар аюулгүй, нэр төртэй орчинг бүрдүүлэх болтугай. (Дуу 28:7)

12. Бурхан минь, Маврикид эмэгтэйчүүдийг үнэлдэггүй хүмүүсийн сэтгэлд Та ажиллаач. Ажлын байран дахь хүйсийн ялгаварлалыг үгүй болгох болтугай (Ром 2:11)

13. Эзэн минь, Мозамбикийн өрх толгойлсон эмэгтэйчүүд ядуурлаас гарах боломжтой болж, гэр бүлээ авч явахад шаардлагатай нөөц боломжийг олж авахад нь Та туслаач. (Дуу 34:6)

14. Аав аа, Руандагийн эрчүүд гэр бүлээ хайрлан халамжлахад эхнэрүүдтэйгээ нэг болох болтугай. (Мт. 11:28)

15. Эзэн минь, Танзани дахь гэр бүлүүдэд хайр энэрэлээр нэгдмэл байдал тогтож, хосууд гэр бүлээ амар амгалан байлгахын тулд хамтран зүтгэх болтугай. (Малахи 2:16)

16. Бурхан минь, Уганда дахь бэлгийн хүчирхийлэлд өртөн эмэгтэйчүүд эдгэрч, тэдний дуу хоолой нийгэмд сонсогдож, өөрчлөлт авчрах болтугай. (Дуу 103:6)

17. Аав аа Эсватинийн хүчирхийлэл, ядуурал, гай гамшгаас үүдэн сэтгэл зүрх нь шархалсан хүүхдүүдийн зүрхийг эдгээж, найдвар, аюулгүй байдал, амар тайвныг тогтоогооч. (Иер. 17:14)

18. Эзэн минь, Өмнөд Африкт бие махбодийн хүчирхийлэл, хүйсийн хүчирхийлэл, эмэгтэйчүүдийн амийг хөнөөж буй нөхцөлд хүчирхийллийн сүнснийг үндсээр нь устгаж, гэм нүгэл үйлдэгчдийн сэтгэл зүрхэнд өөрчлөлт авчраач. (Гал. 5:19–21)

19. Бурхан минь, Сомали дахь эмэгтэйчүүдийг гадуурхдаг соёлын хандлага, үүрэг хариуцлагад өөрчлөлт авчирч, тэд хүссэндээ хүрэх эрх чөлөөг эдлэхэд туслаач. (Дуу 9:9)

20. Эзэн минь, Өмнөд Суданы энх тайвныг хөгжүүлэхэд эмэгтэй удирдагчдын зориг, мэргэн ухааныг ашиглаж буйд баярлалаа. Тэдний эвлэрэл авчрах энэ ажлыг Та ерөөгөөч. (Мт. 5:9)

21. Эзэн минь, Танзани улсад гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн амьдралд Та оролцож, тэднийг хамгаалаач. (1 Кор. 13:4–7)

22. Эзэн минь, Занзибар болон Пембад Христэд цөөнх учраас бусдаас тусгаарлагдсан байдаг. Тэднийг тэвчээртэй байж, төрийн шийдвэр гаргах түвшинд оролцох хүчээр тэтгээч. (Ром 5:3–5а)

23. Бурхан минь, Ковидын цар тахлын улмаас ажил, сургууль нь зогссон Замбийн эмэгтэйчүүдэд боловсрол, санхүүгийн боломжуудыг дахин сэргээж өгөөч. (Сур. 1:5)

24. Эзэн минь, хөрш орнуудад ажил хийж буй эцэг эхийнх нь оронд ач, зээгээ харж буй Зимбабвегийн эмээ нарыг Та хүч чадлаар тэтгээч. (Иса. 40:31)

25. Эсватинийн эрүүл мэндийн салбарт тусламжийн санхүүжилт буурсантай холбоотойгоор, төрийн удирдагчдад мэргэн ухаан өгөөч. (Иаков 1:5)

26. Бурхан минь, Өмнөд Африкийн эдийн засаг дахин сэргэж, хүмүүс, ялангуяа залуус ажилтай болж, өөрсдийгөө тэжээж чадах чадвартай болох болтугай. (2 Тес. 3:10–12)

27. Бурхан минь, Уганда дахь боловсрол, эрүүл мэнд, санхүүгийн боломжоос гадуур байгаа эмэгтэйчүүдийн амьдралд шинэ боломжуудыг нээж өгөөч. (Дуу 146:7)

28. Эзэн минь, Занзибар болон Пембагийн төрийн албан тушаалтнуудад ядуурлыг бууруулж, ард иргэддээ ажлын байр бий болгох чиглэлд мэргэн ухааныг хайрлаач. (Дэд хууль 8:18)

29. Эзэн минь, Эсватинийн залуус өөрсдийн ур чадварыг ашиглан орон нутагтаа бизнес эхлүүлэх шинэлэг санааг олж харах болтугай. (Кол. 3:23)

30. Бурхан минь, Өмнөд Африкт сураггүй алга болсон хүүхдүүдийг уй гашууд автсан эцэг эхчүүдэд нь буцаан өгөөч. Гэмт хэрэгтнүүдийг шүүхийн өмнө авчирч, Танд итгэх итгэлээр сэтгэл зүрх нь шинэчлэгдэх болтугай. (Иер. 31:17)

31. Эзэн минь, Занзибар арлын Зингве залбирлын бүлгийн эмэгтэйчүүдийн 98 хувь нь бичиг үсэггүй байна. Тэд залбирлын хуанлиг дагаж, Библи уншиж сурах боломжтой болох замыг Та гаргаж өгөөч. (Сур. 4:13)

Монголын төлөө залбирах сэдвүүд -----

1. Нэвтрүүлэг илүү олон сувгаар хүрэх боломж нээгдэхийн төлөө
2. залбиралын хуанли хүлээн авдаг чуулган болон хүмүүс нэмэгдэж, залбиралын цугларалт өргөжихийн төлөө
3. Эмэгтэйчүүдийн хориход нэвтрүүлэг цацагдахын төлөө

후원안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송
최초 입금 후 사무실로 연락주시기 바랍니다.